



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 12 сарын 17 өдөр

Дугаар А/95

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 1.4.6, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 47 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/346 дугаар захирамж, тус газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Сити тур" төслийн 2 автобусыг 2018 оны 11 дүгээр сарын 01-нээс 2019 оны 04 дүгээр сарын 30-ыг дуустал 6 сарын хугацаанд "Эрдэм транс" ХХК-тай гэрээ байгуулан дулаан гражид хадгалуулахыг Бодлого төлөвлөлтийн хэлтэс /В.Батчимэг/-т даалгасугай.

2. Хадгалалтын төлбөр болох хавсралтад дурьдсан 5,040,000 /таван сая дөчин мянга/ төгрөгийг Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/346 дугаар захирамжаар батлагдсан "Сити тур" төслийн онлайн захиалгын сайт нээх зардал болон шатахууны зардлаас шилжүүлэн тооцож гаргахыг нягтлан бодогч /Б.Батцож/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.БАТСҮХ

1150500835

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 12
сарын 17 өдрийн А/95 дугаар
тушаалын хавсралт

5284525 СБТ 8936 1118263502

АВТОБУС ХАДГАЛУУЛАХ
ТӨСВИЙН ЗАДАРГАА

2018 оны 12 дугаар сарын 17

Улаанбаатар хот

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Хугацаа	Нэгж үнэ	Нийт дүн
1	Автобус /4100 УНЗ/	ш	1	6 сар	420,000	2,520,000
2	Автобус /4102 УНЗ/	ш	1	6 сар	420,000	2,520,000
НИЙТ						5,040,000